

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төслийн талаар

Хууль тогтоомжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасны дагуу Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төслийн зохицуулалтад хамаарах мэдээллийг агуулсан дэлгэрэнгүй танилцуулгыг бэлтгэв.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төсөл

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны дагуу Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлага байна гэж үзсэн тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан анхдагч хуулийн төсөл боловсруулсан болно.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төсөл нь 8 бүлэг 52 зүйлтэй бөгөөд уг хуулийн зорилго нь хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд нийгэм, эдийн засгийн дэд бүтцийг бүрдүүлэхэд төсвийн хөрөнгө оруулалтын төслийн төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт, хөрөнгийн удирдлага, ашиглалтыг ил тод, үр ашигтай хэрэгжүүлэхтэй холбогдуулан төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын эрх зүйн нэгдмэл орчныг бүрдүүлэхэд оршино.

Хуулийн төслийн зохицуулалтуудыг бүлэг, зүйл тус бүрээр доорх хүснэгтэд дэлгэрэнгүй тайлбарлав.

Бүлэг, зүйлийн нэр, дугаар	Тайлбар
Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл 1) Хуулийн зорилго 2) Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага /цаашид “ТХОУ” гэх/-ын хууль тогтоомж 3) Хуулийн үйлчлэх хүрээ 4) Нэр томъёоны тодорхойлолт 5) ТХОУ-ын зарчим 6) Төсвийн хөрөнгө оруулалтын үе шат 7) Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн ангилал, төрөл 8) ТХОУ-ын цаглавар 9) Төсвийн хөрөнгө оруулалтад хориглох зүйл	- Хуулийн төслийн эхний бүлэгт ТХОУ-ын тухай хуулийн зорилго, хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээг тодорхойлсон. Тодруулбал, уг хууль нь улсын болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, гадаадын зээл, тусламж болон ТХХТ-ийн төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн төлөвлөлт, үнэлгээ, эрэмбэлэлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт болон хөрөнгийн удирдлага, ашиглалтын удирдлагыг хэрэгжүүлэхэд үйлчилнэ. Мөн, ТХОУ-д хамаарах нийт 39 нэр томъёоны тодорхойлолт, ТХОУ-д баримтлах 11 зарчим болон төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт болон хөрөнгийн удирдлага гэсэн ТХОУ-ын үндсэн 5 үе шатыг хуульчлан тогтоосон. - Төслийн төсөвт өртөг болон хэрэгжих хугацаанаас нь хамааруулж, төсвийн хөрөнгө оруулалтын төслийн 5 түвшний ангиллыг хуульд шинээр тодорхойлж, төслүүдийг нийгэм, эдийн засгийн зэрэг салбараар төрөлжүүлэн заасан. Түүнчлэн, ТХОУ-ын цаглавар болон төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэхэд хориглох зүйлийг хуулийн төсөлд тодорхойлсон.

	<table><tr><th>№</th><th>Төслийн ангилал</th><th>Төсөвт өртөг /төгрөг/</th><th>Хэрэгжих хугацаа /жил/</th></tr><tr><td>1.</td><td>I түвшин буюу жижиг</td><td>5 тэрбум хүртэл</td><td>Хоёр хүртэл</td></tr><tr><td>2.</td><td>II түвшин буюу дунд</td><td>5 тэрбумаас дээш 20 тэрбум хүртэл</td><td>Гурав хүртэл</td></tr><tr><td>3.</td><td>III түвшин буюу том</td><td>20 тэрбумаас дээш 100 тэрбум хүртэл</td><td>Дөрөв хүртэл</td></tr><tr><td>4.</td><td>IV түвшин буюу хөгжлийн</td><td>100 тэрбумаас дээш 350 тэрбум хүртэл</td><td>Тав хүртэл</td></tr><tr><td>5.</td><td>V түвшин буюу мега</td><td>350 тэрбумаас дээш</td><td>Таваас дээш</td></tr></table>	№	Төслийн ангилал	Төсөвт өртөг /төгрөг/	Хэрэгжих хугацаа /жил/	1.	I түвшин буюу жижиг	5 тэрбум хүртэл	Хоёр хүртэл	2.	II түвшин буюу дунд	5 тэрбумаас дээш 20 тэрбум хүртэл	Гурав хүртэл	3.	III түвшин буюу том	20 тэрбумаас дээш 100 тэрбум хүртэл	Дөрөв хүртэл	4.	IV түвшин буюу хөгжлийн	100 тэрбумаас дээш 350 тэрбум хүртэл	Тав хүртэл	5.	V түвшин буюу мега	350 тэрбумаас дээш	Таваас дээш
№	Төслийн ангилал	Төсөвт өртөг /төгрөг/	Хэрэгжих хугацаа /жил/																						
1.	I түвшин буюу жижиг	5 тэрбум хүртэл	Хоёр хүртэл																						
2.	II түвшин буюу дунд	5 тэрбумаас дээш 20 тэрбум хүртэл	Гурав хүртэл																						
3.	III түвшин буюу том	20 тэрбумаас дээш 100 тэрбум хүртэл	Дөрөв хүртэл																						
4.	IV түвшин буюу хөгжлийн	100 тэрбумаас дээш 350 тэрбум хүртэл	Тав хүртэл																						
5.	V түвшин буюу мега	350 тэрбумаас дээш	Таваас дээш																						
Хоёрдугаар бүлэг. ТХОУ-ын талаарх төрийн байгууллагын бүрэн эрх, чиг үүрэг 10) Засгийн газрын бүрэн эрх 11) Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх 12) Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 13) Төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрэн эрх 14) Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Зөвлөлийн бүрэн эрх 15) Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагчийн бүрэн эрх 16) Захиалагчийн чиг үүрэг	- Хуулийн төслийн 2 дугаар бүлэгт төрийн байгууллагуудын ТХОУ-ын талаарх бүрэн эрх, чиг үүргийг тусгасан бөгөөд Засгийн газар төсвийн хөрөнгө оруулалтын тэргүүлэх салбарыг тогтоох, төсвийн багцад хөрөнгийн зохицуулалт хийх, салбар хоорондын уялдаа, нэгдсэн удирдлагыг хангах бүрэн эрхтэй байхаар зохицуулсан. - Сангийн сайд төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, төсвийн хуваарилалтыг батлах, шаардлага хангаагүй төслийг зогсоох санал гаргах бүрэн эрхтэй бөгөөд Сангийн яам нь төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалтын нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлж, төслийг үнэлж эрэмбэлэх, нэгдсэн жагсаалт гаргах, санхүүжилтийг нээх, шаардлага хангаагүй төсөлд санхүүжилт олгохгүй байх, ТХО-ын нэгдсэн тайлан гаргах, аргачлал боловсруулах, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж, цахим системийн удирдлагыг хариуцна. - Төсвийн ерөнхийлөн захирагч төсөлд үнэлгээ хийх, санхүүжилт болон төсвийн эрсдэлийг тооцох, хэрэгжилт ба гүйцэтгэлийн хяналт, тайлагналтыг бүрэн хариуцна. Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ болон хот, тосгоны Зөвлөл орон нутгийн хөрөнгө оруулалтын төслийн жагсаалтыг бодлого, шаардлагад нийцүүлэн баталж, хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэнэ. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга шаталсан үнэлгээний дагуу төслийн саналыг эрэмбэлэн ТЭЗ-д хүргүүлэх, батлагдсан төслийн хэрэгжилт ба хөрөнгийн удирдлагыг хариуцахаар хуульд тусгасан. Захиалагчийн чиг үүргийг тодорхой, дэлгэрэнгүй тусгасан бөгөөд төслийн төлөвлөлт, хэрэгжилт, гэрээ болон зураг төсөлд хяналт тавьж, гүйцэтгэлийг үнэн зөв цахим системд баталгаажуулах үүрэгтэй.																								
Гуравдугаар бүлэг. Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, төслийн үнэлгээ, тавигдах шаардлага 17) Төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, тэргүүлэх салбар 18) Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр, зориулалт 19) Төсвийн хөрөнгө оруулалтын төсөлд тавигдах шаардлага 20) Төслийн төлөвлөлт, бэлтгэл ажлыг хангах 21) Техник, эдийн засгийн үндэслэл	- Хуулийн төслийн 3 дугаар бүлэгт төсвийн хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлж, тэргүүлэх салбарыг Засгийн газар тогтоохоор заасан. Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрт улсын болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, гадаадын зээл, тусламж, болон ТХХТ-ийн санхүүжилт багтах бөгөөд эдгээр эх үүсвэрийг улс, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдсан, нийгэм, эдийн засгийн үр өгөөжтэй, хуулийн төсөлд заасан 5 ангиллын төслүүдийг хэрэгжүүлэхэд зарцуулах талаар зохицуулсан. - Төсвийн хөрөнгө оруулалтын төсөлд тавигдах шаардлагуудыг тодорхой, дэлгэрэнгүй зохицуулж, төсөл нь зураг төсөл, холбогдох зөвшөөрөл, ТЭЗҮ, нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашиг, урсгал зардлын тооцоо, бодлогын уялдаа зэрэг нийтлэг техникийн болон бодлогын шаардлагуудыг заавал хангах шаардлагыг тусгасан. - Хуулийн төсөлд өнөөг хүртэл хууль, эрх зүйн зохицуулалт бүрхэг, хууль тогтоомж байхгүй ТЭЗҮ болон ТЭЗҮ-гийн тайлангийн талаар тодорхой зохицуулсан бөгөөд IV–V ангиллын төсөлд заавал ТЭЗҮ боловсруулахаар тусгасан.																								

22) Техник, эдийн засгийн үндэслэлийн тайлан 23) Төслийн нийгмийн ач холбогдол болон эдийн засгийн үр ашиг 24) Төслийг үнэлж, эрэмбэлэх 25) Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төслийг төлөвлөх, үнэлэх, шийдвэрлэх 26) Төслийг төсөвт тусгах	ТЭЗҮ-г төсөвт өртгийн 3%-иас хэтрэхгүй зардлаар хийх бөгөөд эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол нь тогтоогдсон төсөлд зураг төсөл боловсруулна. Төсөлд нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийн шинжилгээг хийх талаар тусгасан. - Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийг сум, дүүрэг – аймаг, нийслэл –салбарын түвшин – улсын хэмжээнд буюу 3 түвшинд шаталсан үнэлгээний тогтолцоогоор үнэлж, эрэмбэлэх бөгөөд үнэлгээний тайлан, нэгдсэн жагсаалтыг цахим системд нийтэд нээлттэй байршуулахаар зохицуулсан. - Гадаадын зээл, тусламжийн төслүүд нь хөгжлийн түншийн бодлого болон Монгол Улсын хөгжлийн зорилтод нийцсэн, эдийн засгийн өгөөж өндөр, нийгэм, байгаль орчны сөрөг нөлөө багатай байхаар тусгасан бөгөөд эдгээр төслийн төлөвлөлт, үнэлгээг төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн тогтолцоонд нийцүүлэн хийнэ. - Хуулийн шаардлага болон иж бүрдлийг хангасан төсвийн хөрөнгө оруулалтын төслийг төсөвт тусгах бөгөөд хэрэгжиж буй төсөл, их засвар, шинээр эхлэх төсөл гэсэн эрэмбийг баримталж төсөвт тусгахыг хуульчилсан.
Дөрөвдүгээр бүлэг. Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт 27) Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилт 28) Эрх шилжүүлэх, багц хуваарилах 29) Төслийн гэрээний удирдлага 30) Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилт 31) Төслийн санхүүжих дүнд хийх хөрөнгийн зохицуулалт 32) Төслийн хэрэгжилтэд тавих хяналт 33) Төсөвт өртгийн өөрчлөлт 34) Тайлагналт, үр дүн	- Төсвийн хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэх үе шатны зохион байгуулалт, хяналт, санхүүжилт, худалдан авалт, тайлагналын нийтлэг журам болон оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг энэ бүлэгт зохицуулсан. Төсөл нь батлагдсан төсөв, хууль тогтоомж, цахим бүртгэлийн кодын дагуу хэрэгжих бөгөөд худалдан авах ажиллагааг хугацаанд нь зохион байгуулж, зураг төсөл, өртгийг хэрэгжилтийн явцад өөрчлөхийг хориглоно. - Хуулийн төсөлд төслийн эрхийг шилжүүлэх, багц хуваарилах журмыг тогтоосноос гадна төсөл хэрэгжүүлэх гэрээний удирдлагын талаар тусгасан. Төсөл хэрэгжүүлэх гэрээний төрөл нь уламжлалт тендерийн нөхцөлтэй байхаас гадна олон улсын жишиг гэрээг /FIDIC/ байгуулах боломжийг бүрдүүлж, гэрээнд заавал тусгах агуулга, нөхцөлийн талаар авч үзсэн. - Төсвийн хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэх хүрээнд гүйцэтгэлийн санхүүжилтийг олгох талаар зохицуулсан, тодруулбал, захиалагчаас гэрээ болон батлагдсан төсөвт өртөг, магадлалын дүгнэлтээр санхүүжилтийг үе шат бүрээр хянаж, баталгаажуулсны дагуу санхүүжилтийг олгоно. Түүнчлэн, Засгийн газар нь тухайн жилийн төсвийн хуулиар батлагдсан төслийн санхүүжих дүнд багтааж, төслийн батлагдсан төсөвт өртөг, нэр, байршил, хүчин чадлыг өөрчлөхгүй, төслийн хэрэгжилт, гүйцэтгэлд үндэслэн хөрөнгийн зохицуулалтыг хийх талаар тусгасан. - ТХОУ-ын тухай хуулийн төслийн бас нэг чухал зохицуулалт бол төслийн хэрэгжилтэд тавих хяналт бөгөөд төслийг хэрэгжүүлэхэд захиалагчийн техникийн хяналт, зураг төсөл зохиогчийн хяналт болон хөндлөнгийн хяналтыг тавина. Захиалагчийн техникийн хяналт болон зураг төсөл зохиогчийн хяналт хэрэгжүүлэгч нь төслийн явц бүрд зураг төсөл, норм, стандартын дагуу хяналт тавьж, тэмдэглэл, дүгнэлт, тайлан, зөвлөмж гаргах ба батлагдсан төсөвт өртгийг нэмэгдүүлэх үр дагавартай шийдвэр гаргахыг хориглоно. - Түүнчлэн, зайлшгүй шаардлага, үндэслэл, баримт, шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд төслийн

	төсөвт өртгийг өөрчлөх нөхцөлийн талаар болон төслийн хэрэгжилтийн тайлагналт, үр дүнгийн талаарх хуулийн зохицуулалтыг тусгасан. Төслийн санхүүжилт, явц, үр дүнг олон нийтэд цахим системээр тогтмол ил тод, нээлттэй мэдээлж, шинэчлэх бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагч нь ашиглалтад орсон барилга байгууламж, хэрэгжүүлсэн төслийн үр нөлөө, үр дүнг нэгтгэн тайлагнана.
Тавдугаар бүлэг. ТХОУ-ын ил тод, нээлттэй байдал, цахим системийн удирдлага 35) Мэдээллийн нэгдсэн сан, ил тод, нээлттэй байдал 36) Олон нийтийн оролцоо 37) Цахим системийн удирдлага, зохион байгуулалт	- Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжилт, хяналт, тайлагналт зэрэг бүх мэдээллийг багтаасан нэгдсэн мэдээллийн сантай байх бөгөөд төрийн болон албаны нууцаас бусад төсвийн хөрөнгө оруулалтын мэдээлэл олон нийтэд ил тод, нээлттэй байна. Сангийн яам нь мэдээллийн санг цахим системд ил тод байлгах нөхцөлийг хангаж, холбогдох байгууллагууд шаардлагатай мэдээллийг бүрдүүлж өгөх үүрэгтэй. - Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, тайлагналтад олон нийтийн оролцоог хангах талаар зохицуулсан, тодруулбал мэдээллийг хүртээмжтэй, ил тод, ойлгомжтой түгээж, хэлэлцүүлгийн тов, байршлыг урьдчилан мэдэгдэх ба иргэн, хуулийн этгээд, иргэний нийгмийн байгууллагын саналыг харгалзан үзэх зарчмыг тусгасан. Иргэдийн саналыг цахим системээр авч, төслийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, тайлагналтад харгалзаж үзэх бөгөөд шаардлагатай тохиолдолд орон нутгийн Засаг даргатай хамтран хэлэлцүүлэг зохион байгуулж болно. - ТХОУ-ыг цахим системээр дамжуулан хэрэгжүүлэх буюу их өгөгдөл, хиймэл оюун ухаанд тулгуурлан төслийг төлөвлөх, үнэлэх, сонгох, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Сангийн яам цахим системийн удирдлагыг хэрэгжүүлэх бөгөөд бүртгэлтэй хэрэглэгч нь мэдээллийг оруулах, бүртгэх, баталгаажуулах, илгээхдээ хууль, журмыг мөрдөж, мэдээллийн бүрэн, үнэн зөв, аюулгүй байдлыг хангаж ажиллана. Цахим системд шаардлагатай баримт бичиг, мэдээллийг бүрдүүлээгүй тохиолдолд төслийг төлөвлөлтөд тусгахгүй.
Зургаадугаар бүлэг. Хөрөнгийн удирдлага, ашиглалт, түүний үр өгөөж 38) Төсвийн хөрөнгө оруулалтын хөрөнгийн удирдлага 39) Хөрөнгийн бүртгэл, өмчлөл 40) Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн сан 41) Хөрөнгийн ашиглалт, сайжруулалт 42) Төсвийн хөрөнгө оруулалтын хөрөнгийн үр өгөөж	- Хуулийн төслийн 6 дугаар бүлэгт төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг хэрхэн удирдах, төрийн болон орон нутгийн өмчид бүртгэх, хууль тогтоомжид заасан шаардлага, норм, стандартын дагуу ашиглах, барилга байгууламжид урсгал болон их засварыг тухай бүр тогтмол хийх, тухайн хөрөнгийн үр өгөөжийг тооцдог байх талаар тодорхой зохицуулсан. Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон бүх хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмчид хамаарах бөгөөд эдгээрийн удирдлагыг бусад хууль тогтоомжтой уялдуулан зохицуулах талаар дурдсан. - Захиалагч, ашиглагч нь төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон өмчийн мэдээллийг өмчийн мэдээллийн санд бүртгэх бөгөөд өмчийн мэдээллийн сан нь өмчийн ангилал, бүртгэл, тооллого, эзэмшигч, өмчийн хөдөлгөөн, тайлан, үнэлгээний мэдээллийг төвлөрүүлнэ. - Хөрөнгийн эзэмшигч, өмчлөгч, ашиглагч нь барилга, тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглах, хэвийн нөхцөлийг хангах, хяналт тавих үүрэгтэй. Барилга, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацааг уртасгах, элэгдсэн тоног төхөөрөмжийг солих, нэмэлт тоног төхөөрөмж суурилуулах зэрэг сайжруулалтыг хийх, чанарын баталгаат хугацаанд

	гарсан гэмтэл, согогийг гүйцэтгэгч засварлаж, хариуцлага хүлээх зэрэг талаар тусгасан. ТЭЗ нь төслийн үр дүн, хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийг үнэлж, цахим системд тайлагнах бөгөөд бодлого, төлөвлөлт, цаашид авах арга хэмжээний зөвлөмж боловсруулна.
Долоодугаар бүлэг. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын сан 43) Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын сан 44) Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын сангийн эх үүсвэр 45) Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын сангийн хөрөнгийн зарцуулалт 46) Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын сангийн ил тод байдал, тайлагналт 47) Төслийн гүйцэтгэгчийг үнэлэх	- Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын сангийн талаар хуулийн төсөлд тусгасан бөгөөд энэхүү сан нь дэд бүтцийн салбарын технологийн хөгжлийг дэмжиж, норм, нормативыг боловсронгуй болгох, төслийн эрсдэлийг бууруулах зорилготой. ТХОУ-ын сангийн хөрөнгийг төслийн салбар, ангиллаас хамааран гэрээний үнийн тодорхой хувь хэмжээгээр төвлөрүүлэх ба сангийн эх үүсвэр нь төрийн сангийн нэгдсэн дансанд төвлөрч, төсөл хэрэгжих бүрд гэрээний үнийн дүнгээс тооцон төвлөрүүлнэ. - Сангийн хөрөнгийг зөвхөн технологийн хөгжил, норм, нормативын баримт бичгийг боловсронгуй болгох, төслийн эрсдэлээс сэргийлэх, хөрөнгийн үр ашиг, ашиглалт, үр өгөөжийг үнэлэх, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага, цахим системийг сайжруулах, хүний нөөцийг чадавхжуулах зэрэг зориулалтаар зарцуулна. - Сангийн үйл ажиллагаа, орлого болон хөрөнгийн зарцуулалт олон нийтэд ил тод, нээлттэй байна. Орлого, зарцуулалтын тайланд санд төвлөрсөн орлогын хэмжээ, хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэсэн ажил, арга хэмжээ, хүрсэн үр дүнгийн мэдээллийг тусгана. - Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн гүйцэтгэгчийг жил бүр чанар, хугацаа, хөрөнгийн зарцуулалт, үр дүн, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл зэрэг шалгуураар үнэлж, ногоон, шар, улаан гэсэн ангилалд оруулж, ногоон жагсаалтын гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөрийг олгох зэрэг урамшуулал үзүүлэхээр хуулийн төсөлд тусгасан.
Наймдугаар бүлэг. Бусад зүйл 48) Маргаан шийдвэрлэх 49) Хохирол, гэм хор нөхөн төлүүлэх 50) Хариуцлага хүлээлгэх үндэслэл 51) Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага 52) Хууль хүчин төгөлдөр болох	- Төгсгөлийн бүлэгт төсвийн хөрөнгө оруулалтын явцад үүссэн маргааныг талууд харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, арбитр болон шүүхээр шийдвэрлүүлэх талаар зохицуулсан. Тендерийн маргааныг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмаар шийдвэрлэнэ. - Хууль зөрчсөн үйлдлээс үүссэн төсвийн хөрөнгө, бусад эх үүсвэрт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх ба гэрээний тал үүргээ биелүүлээгүйгээс үүссэн хохирлыг нөгөө талаас гэрээнд заасан журмаар нэхэмжлэх эрхтэй. - Хууль зөрчсөн төслийн жагсаалт батлахгүй байх, хууль зөрчсөн, эрх шилжүүлсэн этгээдэд хариуцлага хүлээлгэх талаар зохицуулсан бөгөөд ийнхүү хариуцлага тооцсон нь эрүүгийн болон захиргааны хариуцлагаас чөлөөлөхгүй. Мөн хуульд заасан хориглох зүйлийг зөрчсөн эрх бүхий этгээд, удирдах болон гүйцэтгэх албан хаагчид ногдуулах Төрийн албаны тухай хуулиар сахилгын шийтгэл хүлээлгэх, төслийн явцад нэмэлт ажил гарсан, эсхүл ажлыг өөрчлөн хийх зайлшгүй шаардлага гарсан зэрэг нөхцөлд захиалагчид урьдчилан мэдэгдээгүй, шийдвэрлүүлээгүй бол холбогдох зардал, эрсдэлийг гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр хариуцах талаар тус тус зохицуулсан. - Хууль хүчин төгөлдөр болох хугацааг тусгана.

Хуулийн төсөлд тусгасан нэр томъёоны тайлбарын талаар

Хууль тогтоомжийн тухай хуулийн 30.4-т заасны дагуу хуулийн төслийн 4 дүгээр зүйлд ТХОУ-д хамаарах нийт 39 нэр томъёоны тодорхойлолтуудыг оруулсан бөгөөд хуулийн төслийн хувьд шинээр нэр томъёог тусгахаас гадна Төсвийн тухай, Өрийн удирдлагын тухай, Барилгын тухай зэрэг холбогдох хууль тогтоомжтой уялдуулсан, эшилсэн тодорхойлолтуудыг мөн төсөлд тусгасан.

ТХОУ-д хамаарах төсвийн хөрөнгө оруулалт, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага, төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, төслийн төлөвлөлт, төслийн хэрэгжилт, төслийн санхүүжилт, тайлагналт, хяналт, гүйцэтгэл, дэд бүтэц, техник, технологийн хяналт, зөвлөх үйлчилгээ, магадлалын дүгнэлт, нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашиг, үр өгөөж, техник, эдийн засгийн үндэслэл зэрэг 25 нэр томъёог тодорхойлж, 14 нэр томъёонд бусад хуулиас эшлэл авсан.

Бусад улс орны хууль тогтоомжийн талаар

Олон улсын харьцуулсан судалгааны хүрээнд бусад улс орнуудын төсвийн хөрөнгө оруулалтын харилцааг зохицуулж буй хууль тогтоомжийг судлан үзэхэд дийлэнх улс оронд төсвийн хуульдаа ерөнхий зохицуулалтыг тусгаж, нарийвчилсан харилцааг үйл ажиллагааны журам, аргачлалд тусган зохицуулдаг байна. Судалгаанд авч үзсэн улс орнуудаас Вьетнам болон Лаос улс төсвийн хөрөнгө оруулалтын тусгайлсан хуультай тул ТХОУ-ын тухай хуулийн төслийг боловсруулахад эдгээр улсын хууль тогтоомжийг түлхүү жишиг болгон ашиглав.

Вьетнам улсын Төсвийн хөрөнгө оруулалтын тухай хууль нь 6 бүлэг, 103 зүйлтэй бөгөөд хөрөнгө оруулалтын удирдлагын харилцаа, холбогдох этгээдийн эрх, үүрэг, хариуцлага, төсвийн хөрөнгө оруулалтын объектын төрлүүд, төслийн ангилал, ил тод байдал, хориглох зүйлс, хөрөнгө оруулалтын үйл явц, ТЭЗҮ-ийн тайланд тусгах агуулга болон төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт, шалгалтын талаар зохицуулдаг. Уг хуульд төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын зарчим болон төсвийн хөрөнгө оруулалтад хориглох зүйлсийг тус бүр тухайлсан зүйлд тусгаж, төсвийн хөрөнгө оруулалтын үндсийг тодорхойлсон. Төслийн ангиллыг тогтоохдоо салбаруудыг бүлэглэж, бүлэг тус бүр дээр хөрөнгө оруулалтын хэмжээгээр нь гурван шатлал дүн тогтоож, А, В, С бүлэгт эрэмбэлэн ангилдаг байна. Үүний дагуу төсвийн хөрөнгө оруулалтын үйл явцын бүхий л шатанд тавигдах шаардлага, хийгдэх үйл ажиллагааг төслийн ангиллуудад ялган тодорхойлсон нь төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг тогтоосон хугацаанд, илүү үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлдэг.

Лаос улсын Төсвийн хөрөнгө оруулалтын тухай хууль нь 7 хэсэг, 9 бүлэг, 105 зүйлтэй бөгөөд төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, зарчим, хөрөнгө оруулалтын төрөл, ангилал, хөрөнгө оруулалтын үйл явц, төсөлд өөрчлөлт оруулах, санхүүжилтийг шилжүүлэх, төслийг түдгэлзүүлэх болон хүчингүй болгох нөхцөл, оролцогч байгууллагуудын чиг үүрэг, хяналт, шалгалт болон маргаан шийдвэрлэх асуудлыг зохицуулдаг. Төслүүдийг (1) стратегийн чухал ач холбогдолтой, улс орны хөгжлийг дэмжих улсын хэмжээний хөрөнгө оруулалтын төсөл болон (2) хөрөнгө оруулалтын хэмжээ, хэрэгжилтийн хугацаа, төлбөрийн хугацаа зэргээс хамааран 5 түвшинд ангилдаг. Төслийн ангиллаас хамааран хөрөнгө оруулалтын үе шатуудад тавигдах шаардлага, хийгдэх үйл ажиллагааг ялган тодорхойлсон нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг саадгүй, бүтээмжтэй хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлдэг байна. Төслийн явцад тодорхой нөхцөл байдал тогтоогдсон

тохиолдолд төсөлд өөрчлөлт оруулах, санхүүжилтийг шилжүүлэх, төслийг түдгэлзүүлэх болон хүчингүй болгох зохицуулалтуудыг хуульд тусгасан нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны уян хатан, үр дүнтэй байдлыг хангадаг байна.

Ийнхүү олон улсын туршлагыг судалж, Дэлхийн банк, ОУВС зэрэг олон улсын байгууллагуудын төсвийн хөрөнгө оруулалтын талаар өгсөн дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн ТХОУ-ын тухай хуулийн төсөлд манай улсын өөрийн онцлог, тогтолцоонд тохируулан холбогдох зохицуулалтуудыг тусгав. Тухайлбал, ТХОУ-ын тухай хуулийн төслийн 7 дугаар зүйлд төслүүдийг төсөвт өртөг болон хэрэгжих хугацаанд үндэслэн 5 ангилалд ангилахаар зохицуулж, ангиллаас хамааран төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр, төсөлд тавигдах шаардлага зэрэг асуудлыг ялгамжтай байхаар зохицуулсан. Хуулийн төслийн 5 дугаар зүйлд төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын зарчмыг, 9 дүгээр зүйлд төсвийн хөрөнгө оруулалтад хориглох зүйлийг тус тус тусгасан. Мөн Вьетнам улсын жишгээр ТХОУ-ын тухай хуулийн төслийн 21, 22 дугаар зүйлд ТЭЗҮ болон ТЭЗҮ-ийн тайлангийн талаар зохицуулсан. Түүнчлэн, олон улсын байгууллагуудын дүгнэлт, зөвлөмжийн дагуу ТЕЗ, орон нутаг, улсын төсөв хоорондын уялдаа холбоог сайжруулах, үнэлгээний тогтолцоог сайжруулах, хяналтын тогтолцоог сайжруулах, төслийн явцын өөрчлөлтийг зохицуулах үүднээс хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт төрийн байгууллагын бүрэн эрх, чиг үүргийг, 24 дүгээр зүйлд төслийг үнэлж, эрэмбэлэх асуудлыг, 32 дугаар зүйлд төслийн хэрэгжилтэд тавих хяналтыг, 33 дугаар зүйлд төслийн төсөвт өртгийн өөрчлөлтийг тус тус зохицуулсан.

Дагалдах хуулийн төслүүд

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төслийг дагалдуулан Төсвийн тухай, Өрийн удирдлагын тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Авто замын тухай, Барилгын тухай зэрэг нийт 15 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүд болон ТХОУ-ын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл, ТХОУ-ын тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийг тус тус боловсруулсан болно.

Дагалдах хуулийн төслүүдийн талаар доор товч тайлбарыг оруулвал:

- 1) **Авто замын тухай** хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд уг хуулийн 6 дугаар зүйлд “Авто зам, замын байгууламжийн санхүүжилтийн зохицуулалтад авто замын салбарт төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг ТХОУ-ын тухай хуулиар зохицуулах” агуулга бүхий 6.5 дахь хэсэг нэмж, хуулийн үйлчлэх хүрээг тодорхой болгон хуулиуд хоорондын уялдаа холбоог хангасан. ТХОУ-ын тухай хуулийн төслийн 7 дугаар бүлэгт заасан төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын сангийн зохицуулалтай нийцүүлэх үүднээс авто замын норм, нормативын санд улс, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ хамаарахгүй талаар тусгаж, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх авто замын салбарын төслийн норм, нормативын сангийн эх үүсвэрийг ТХОУ-ын санд төвлөрүүлж, удирдах талаарх өөрчлөлтийг тусгав. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн дагуу Мөн хуулиудын нийцлийг хангаж Авто замын тухай хуулийн “магадлашгүй ажил” гэснийг ТХОУ-ын тухай хуулиас эшлэхээр өөрчлөлт оруулж, “магадлашгүй ажил” гэж

бичсэнийг Монгол хэлний зөв бичих дүрмийн дагуу “магадалшгүй ажил” болгон залруулав.

- 2) **Барилгын тухай** хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд хуулийн үйлчлэх хүрээг тодорхой болгож, хуулиуд хоорондын уялдаа холбоог хангасан. Барилгын тухай хуулийн 2 дугаар зүйл буюу барилгын хууль тогтоомжид төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах болон хөрөнгийн удирдлага, ашиглалттай холбоотой харилцааг ТХОУ-ын тухай хуулиар зохицуулах агуулга бүхий 2.4 дэх хэсэг, мөн 24 дүгээр зүйл буюу барилга байгууламжийн төсвийн тооцоо хийх, төлөвлөх, батлах, хэрэгжүүлэхэд баримтлах зарчимд ТХОУ-ын тухай хуулийн 5.1.6-д заасан хариуцлагатай байх зарчмыг, 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсгийн барилгын ажлын зөвшөөрөл олгохоос татгалзах үндэслэлд “Төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх барилга байгууламжийн хувьд Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн шаардлагыг хангаагүй, уг хуулийг зөрчсөн тохиолдол”-ыг нэмэхээс гадна захиалагч, зураг төсөл зохиогч, барилгын ажил гүйцэтгэгчийн чиг үүрэгт төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламжийн төслийн хувьд ТХОУ-ын тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх гэж тус тус нэмж тусгасан. ТХОУ-ын тухай хуулийн төсөлд заасан ТХОУ-ын сангийн зохицуулалтай нийцүүлэх үүднээс Барилгын тухай хуулийн 5.7-д заасан барилга байгууламжийн норм, нормативын санд улс, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан болон гадаад зээл, туламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл хамаарахгүй талаар тусгаж, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламжийн төслийн норм, нормативын сангийн эх үүсвэрийг ТХОУ-ын санд төвлөрүүлж, удирдах талаарх өөрчлөлтийг тусгав.
- 3) **Зөрчлийн тухай** хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хувьд ТХОУ-ын тухай хуулийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх санкц буюу хариуцлагын хэм хэмжээг нэмэлтээр оруулсан бөгөөд Зөрчлийн тухай хуулийн 11 дүгээр бүлэг буюу үнэт цаас, банк, санхүү, гааль, татвар, хяналт шалгалт, даатгалын журмын эсрэг зөрчилд төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль, журам зөрчих гэсэн 11.36 дугаар зүйл шинээр нэмж оруулсан. Тодруулбал, ТХОУтХ, журамд заасан мэдээлэл, тайлан, дүгнэлт мэдээлэх, илгээх, цахим системд оруулахтай холбоотой үүргээ биелүүлээгүй, зураг төсөл, ТЭЗҮ, магадлал, холбогдох бусад шинжилгээ, судалгаа нь хууль, журам, стандартыг зөрчсөн, эсхүл шаардлагад нийцээгүй болон төсвийн хөрөнгө оруулалтын талаар тогтоосон тусгай журам зөрчсөн тохиолдолд торгох хариуцлага хүлээлгэхээр тусгасан. Хөндлөнгийн хяналт, захиалагчийн техникийн болон зохиогчийн хяналт хэрэгжүүлэгч нь хяналтын чиг үүргээ хуульд заасан ёсоор бүрэн, зохих ёсоор биелүүлээгүй, мөн барилга байгууламжийн төслийн гүйцэтгэгч нь хууль, журамд заасан барилгыг чанартай, тогтоосон хугацаанд нь ашиглалтад оруулахтай холбоотой үүргээ биелүүлээгүй зөрчилд учирсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, мөн торгох хариуцлага хүлээлгэхээр тусгасан.
- 4) **Зөрчил шалган шийдвэрлэх тухай** хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хувьд Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулахтай

холбогдуулан зөрчил шалган шийдвэрлэх байгууллага, албан тушаалтныг тодорхой болгосон нэмэлт оруулсан. Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, барилгын техникийн хяналтын улсын байцаагч, газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч нар төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль, журам зөрчсөн зөрчлийг шалган шийдвэрлэнэ.

- 5) **Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай** хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд ТХОУ-ын тухай хуулийн төсөлтэй уялдуулан үйлчлэх хүрээг тодорхой болгосон, хоорондын уялдаа холбоог хангасан нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулсан. Тодруулбал, хуулийн зохицуулах харилцаанд төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр орон нутагт төсөл төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах болон хөрөнгийн удирдлага, ашиглалт, үр өгөөжийг тооцохтой холбоотой харилцааг ТХОУ-ын тухай хуулиар зохицуулах тухай 2.4 дэх хэсэг, мөн хуулийн 16 дугаар зүйл буюу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төсөв зохицуулалтын 16.5 дахь хэсэгт төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, хяналт тавих ажиллагаанд Төсвийн тухай хууль, ТХОУ-ын хууль тогтоомжийг удирдлага болгох талаар тус тус нэмж тусгав.
- 6) **Өрийн удирдлагын тухай** хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. ТХОУ-ын тухай хуулийн төслийг дагалдуулан Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан. Гадаад зээлийн эх үүсвэр нь төсвийн хөрөнгө оруулалтын нэг үүсвэрт тооцогдох бөгөөд уг асуудлыг зохицуулж буй суурь хууль нь Өрийн удирдлагын тухай хууль юм. ТХОУ-ын тухай хуулийн төсөлд төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийг 5 ангилалд хувааж, гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн ангиллыг тодорхойлон тусгасан. Иймд, Өрийн удирдлагын тухай хуульд уялдуулсан зохицуулалтыг тусгаж, гадаад зээллэгийн эх үүсвэрээр санхүүжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын төсөлд тавигдах шаардлага болон холбогдох бусад зохицуулалтыг тусгаж оруулсан болно. Тодруулбал, хуульд “гадаад зээллэгийн эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын харилцааг ТХОУ-ын тухай хуулиар зохицуулна” гэсэн 3.6 дахь хэсэг, “12.4.Энэ хууль болон Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуульд заасан шаардлагыг хангаагүй, зориулалтад хамаарахгүй төслийг гадаад зээлийн эх үүсвэрээр өр үүсгэн санхүүжүүлэхгүй” гэж тус тус нэмсэн. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг холбогдох салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтцээр дамжуулан хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг хуулийн 24 дүгээр зүйлд нэмж тусгалаа. Түүнчлэн, гадаадын зээлийн журмыг шинэчлэн, тусламжийн журмыг нэгтгэн, эрх зүйн орчин, хууль зүйн зохицуулалтыг сайжруулахтай холбоотой өөрчлөлтийн хүрээнд Төсвийн хуульд оруулж буй нэмэлт, өөрчлөлттэй уялдуулсан өөрчлөлтийг хуульд тусгав.
- 7) **Төмөр замын тээврийн тухай** хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслөөр уг хуулийн 5 дугаар зүйлд төмөр замын салбарт төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр төсөл төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэхтэй холбогдсон харилцааг ТХОУ-ын тухай хуулиар зохицуулах агуулга бүхий

5.2 дахь хэсэг, ТХОУ-ын сантай холбогдуулан төмөр замын норм, стандартын санд улс, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ хамаарахгүй талаарх 13.4 дэх хэсэг, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төмөр замын салбарын төслийн норм, нормативын сангийн эх үүсвэрийг ТХОУ-ын санд төвлөрүүлэн удирдах талаарх 13.5 дахь хэсэг тус бүрийг нэмж, хуулийн үйлчлэх хүрээг тодорхой болгон хууль хоорондын уялдаа холбоог хангасан.

- 8) **Төрийн болон орон нутгийн өмчийн тухай** хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд мөн ТХОУ-ын тухай хуультай уялдуулсан зохицуулалтыг тусган оруулсан. Тодруулбал, уг хуулийн 2 дугаар зүйл буюу үйлчлэх хүрээ зохицуулалтад “төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр бий болсон төрийн болон орон нутгийн өмчид хамаарах энэ хуульд зааснаас бусад хөрөнгийн бүртгэл, ашиглалт, түүний үр өгөөжийг тооцохтой холбоотой харилцааг ТХОУ-ын тухай хуулиар зохицуулна” гэсэн 4 дэх хэсгийг нэмж тусгав.
- 9) **Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай** хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл. ТХОУ-ын үйл ажиллагааны хүрээнд төслийн худалдан авалт, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах процесс нь энэхүү худалдан авах ажиллагааны хуулийн дагуу явагддаг. Иймд, ТХОУ-ын тухай анхдагч хуулийн төсөл болон энэхүү хууль хоорондын харилцан уялдааг хангах, нийцүүлэх, үйлчлэх хүрээг тодорхой болгох өөрчлөлтүүдийг нэмэлт, өөрчлөлтөөр тусгасан. Уг хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт ТХОУ-ын удирдлагын тухай хуулийг хууль тогтоомжид нэмсэн. Харин 3 дугаар зүйл буюу хуулийн үйлчлэх хүрээнд “төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр /улсын төсөв, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, гадаадын зээл, тусламж болон ТХХТ/-ээр хэрэгжүүлэх төслийн худалдан авах ажиллагааг тендерийн хуулиар, төсөл төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах болон хөрөнгийн удирдлага, ашиглалт, үр өгөөжийг тооцохтой холбоотой харилцааг ТХОУ-ын тухай хуулиар зохицуулна” гэсэн 3.5 дахь хэсгийг нэмсэн. Уг хуулийн 17 дугаар зүйл буюу техникийн чадавх болон туршлагын шаардлагад тендерт оролцогчийн техникийн чадавх, туршлагыг үнэлэхэд ТХОУ-ын тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан төслийн гүйцэтгэгчийг үнэлэх зохицуулалтыг харгалзах тухай 17.7 дахь хэсэг, мөн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5 дахь хэсэгт “гэрээний үүргийн гүйцэтгэлийн харилцааг төсвийн хөрөнгө оруулалтын төслийн хувьд Иргэний хууль болон ТХОУ-ын тухай хуулиар зохицуулна” гэсэн нэмэлт, хуулийн 39 дүгээр зүйлд “төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн гэрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39.3-т зааснаас гадна ТХОУ-ын тухай хууль, холбогдох хууль, журамд заасан нөхцөлийг тусгана” гэсэн 39.6 дахь хэсэг тус бүрийг нэмж тусгав.
- 10) **Төрийн хэмнэлтийн тухай** хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр хуулийн үйлчлэх хүрээг тодорхой болгож, хуулиуд хоорондын уялдаа холбоог хангалаа. Уг хуулийн хууль тогтоомж зохицуулалтад ТХОУ-ын тухай хуулийг нэмж, 7.1 дэх хэсэгт захиргааны зориулалтаар барилга шинээр барихыг хориглоно гэж байсныг ТХОУ-ын

тухай хуулиар зохицуулна гэж, хуулийн 13 дугаар зүйлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зохицуулалтын талаарх 13.1.1-13.1.7-д заасныг хүчингүй болгон, 13.1 дэх хэсгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэхтэй холбоотой харилцааг ТХОУ-ын тухай хуулиар зохицуулахаар өөрчлөв. ТХОУ-ын тухай хуулиар тусгайлан зохицуулах болсон тул тул Төрийн хэмнэлтийн хууль дахь шинээр төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой 13.2 дахь хэсэг, хориглох зүйлийн талаарх 13.4 дэх хэсэг, эх үүсвэрийн зохицуулалтад хамаарах 13.6 дахь хэсэг тус бүрийг хүчингүй болгохоор тусгав.

- 11) **Төсвийн тухай** хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Төсвийн хөрөнгө оруулалтын ерөнхий суурь харилцаа өнөөдрийг хүртэл Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль, журмуудаар зохицуулагдаж ирсэн. ТХОУ-ын тухай анхдагч, бие даасан хуулиар зохицуулах болсонтой холбогдуулж Төсвийн тухай хууль дахь төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагад хамаарах зохицуулалтуудыг ТХОУ-ын тухай хуулийн төсөлд шинэчлэн шилжүүлж, хууль хоорондын харилцан уялдааг хангасан нэмэлт, өөрчлөлтүүдийг тусгаж оруулсан. Тодруулбал, хуулийн үйлчлэх хүрээтэй холбогдуулан Төсвийн тухай хуульд “ТХОУ-ын энэ хуульд зааснаас бусад төсвийн хөрөнгө оруулалтын төслийн төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт, хөрөнгийн удирдлага, ашиглалттай холбоотой харилцааг ТХОУ-ын тухай хуулиар зохицуулна.” гэсэн 3.6 дахь хэсгийг нэмж, Төсвийн тухай хууль болон ТХОУ-ын тухай хууль хоорондын нэр томъёоны уялдааг хангах нэмэлт, өөрчлөлтийг 4 дүгээр зүйлд тусгаж, мөн ТЕЗ-ийн чиг үүрэгт ТХОУ-д хамаарах чиг үүргийг нэмсэн. Төсвийн тухай хуульд төсвийн хөрөнгө оруулалтын асуудлыг зохицуулж байгаа 25, 27, 28, 29 дүгээр зүйлийн зохицуулалтуудыг ТХОУ-ын тухай хуулиар зохицуулах болсонтой холбогдуулан хууль хоорондын харилцан уялдааг хангасан өөрчлөлтүүдийг хуулийн төсөлд орууллаа. Мөн үүнээс гадна, төсвийн хөрөнгө оруулалтын бас нэг үүсвэр болох орон нутгийн төсөв болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, бэлтгэх ажиллагааг хангах, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянаж тайлагнах, хөрөнгийн ашиглалтыг удирдахтай холбоотой харилцааг ТХОУ-ын тухай хуультай нийцүүлэн хэрэгжүүлэх талаар Төсвийн тухай хуулийн 60, 67 дугаар зүйлүүдэд нэмж тусгав. Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрт гадаадын зээл, тусламжийн санхүүжилт хамаарч буй бөгөөд Төсвийн тухай хууль дахь тусламжийн хөрөнгийн зарцуулалтыг үр ашигтай, оновчтой байлгах, хууль, эрх зүйн орчныг сайжруулах үүднээс Гадаадын тусламжийн удирдлага, зохицуулалтын талаарх 251 дугаар зүйлийг шинээр нэмж оруулсан. Төсвийн тухай хуулиар Сангийн сайд зээл, тусламжийн санхүүжилт, зээл, тусламжийн нэгдсэн бодлого, зохицуулалтын удирдлагыг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй байдаг. Гадаадын тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор батлагдсан журмаар зохицуулдаг бол гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан тусдаа журмуудаар зохицуулдаг. Эдгээр журмын дийлэнх зохицуулалтууд төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулах, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой процессын зохицуулалтууд бөгөөд 2 журмын нийт зохицуулалтын 50 хувь нь давхардсан, ижил

зохицуулалтууд байдаг тул эрх зүйн орчныг сайжруулах, зохицуулалтыг илүү тодорхой, ойлгомжтой, оновчтой болгох үүднээс Засгийн газрын гадаад зээл, тусламжийн үйл ажиллагааг нэгдсэн журмаар зохицуулдаг болгох зохицуулалтыг Төсвийн тухай хуулийн 11.1.24-т тусгасан. Үүнээс гадна, УИХ болон Засгийн газрын шийдвэрүүдийн дагуу гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хөрөнгийн ашиглалтыг хэмнэлттэй, үр ашигтай хэрэгжүүлэх, төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардлыг бууруулах, оновчтой, чадавхтай хүний нөөцтэй байлгах үүднээс гадаад зээл, тусламжийн төсөл хэрэгжүүлэх нэгжүүдийг ТЕЗ-ийн эрлэх асуудлын хүрээнд яамдын дэргэд нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж болгон өөрчлөх тогтолцооны өөрчлөлтөд шилжиж буйтай холбогдуулан Төсвийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийг “Хөгжлийн түнш, олон улсын байгууллага, хандивлагч орноос Засгийн газрын шугамаар Монгол Улсад хөгжлийн санхүүжилтийн хүрээнд олгож байгаа гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төслийн нэгж нь төсвийн байгууллага байх бөгөөд холбогдох салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэд нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн хэлбэрээр төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ” гэж өөрчлөн найруулсан. Ингэснээр зээл, тусламжийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, хэмнэлтийг бодитоор бий болгох, цаашид тогтвортой эрх зүйн орчинд шилжих боломжийг бүрдүүлж өгсөн. Мөн ТХОУ-ын тухай анхдагч хуулиар төсвийн хөрөнгө оруулалтын харилцааг зохицуулах болсонтой холбогдуулан Төсвийн тухай хуульд давхардсан холбогдох хэсэг, заалтуудыг хүчингүй болгохоор хуулийн төсөлд тусгасан болно.

12)**Хот байгуулалтын тухай** хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд “хот байгуулалт, төлөвлөлтийн үндсэн зарчимд хөрөнгийн эх үүсвэр, санхүүжилтийг тооцсон, санхүү, төсвийн бодлого, төлөвлөлттэй уялдсан байх” гэсэн 4.1.4 дэх зарчмыг нэмж, хот байгуулалт, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл хэрэгжүүлэх тохиолдолд Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийг баримтлахаар тусгаж, уг хуулийн 12.9 дэх хэсэгт хот төлөвлөлтийн суурь судалгаанд байгаль орчин, эдийн засаг, нийгэм, хот байгуулалтын асуудлын зэрэгцээ хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг иж бүрэн хамруулах талаар тодотгон нэмэлт оруулав. Хуулиуд хоорондын уялдаа холбоог хангах зорилгоор 21 дүгээр зүйлд “хот байгуулалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийн хөрөнгө оруулалтын төсөл төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэхэд Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийг удирдлага болгоно” гэсэн 21.2 дахь хэсгийг нэмж тусгав.

13)**Эрүүгийн хуульд** нэмэлт оруулах тухай хуулийн төсөл. Эрүүгийн хуулийн 20.13 дугаар зүйл буюу чанар муутай барилга байгууламж ашиглалтад оруулах гэмт хэрэгт төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр чанар муутай барилга байгууламж барьсан, бариулсан, их засвар хийсэн, хийлгэсэн, чанар муутай тоног төхөөрөмж хүлээн авсан, хүлээлгэн өгсөн, барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулсан, эсхүл энэ талаар шийдвэр гаргасан үйлдлийг хохирлын хэр хэмжээнээс хамааран хүндрүүлэх нөхцөл болгон 3, 4 дэх заалт болгон нэмэв. Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэг буюу авлигын гэмт хэрэгт төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг зориулалтын бусаар зарцуулах, муутгах, ашиглах боломжгүй болгох гэмт хэргийг 22.14 дүгээр

зүйл болгон шинээр нэмсэн бөгөөд төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг зориулалтын бусаар зарцуулах, төсөвт өртгийг үндэслэлгүй нэмэгдүүлснээс төсөвт их хэмжээний хохирол учирсан /1/ болон төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр бий болсон төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, сайжруулалт, хадгалалт, хамгаалалтыг зохих ёсоор хийгээгүйгээс чанар байдлыг хэвийн хэмжээнээс илүүгээр муутгасан, ашиглах боломжгүй болгосон, их засвар хийх шаардлагатай болсон, төсөвт их хэмжээний хохирол учирсан /2/ гэх 2 үйлдлийг төсөлд оруулав.

- 14) **Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай** хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл Эрүүгийн хуульд шинээр гэмт хэрэг нэмэхээр болсон тул уг гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүрэг бүхий байгууллагыг тодорхой болгосон нэмэлт оруулна. Авлигатай тэмцэх байгууллага төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг зориулалтын бусаар зарцуулах, муутгах, ашиглах боломжгүй болгох гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай зохицуулалт нэмнэ.
- 15) **Эрчим хүчний тухай** хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хувьд уг хуулийн 2 дугаар зүйл буюу эрчим хүчний хууль тогтоомж хэсэгт төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр эрчим хүчний салбарын төсөл төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах болон хөрөнгийн удирдлага, ашиглалттай холбоотой харилцааг ТХОУ-ын тухай хуулиар зохицуулах тухай 2.6 дахь хэсэг, мөн 6 дугаар зүйл буюу төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийн зохицуулалтад төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх эрчим хүчний салбарын төслийн ТХОУ-ын санг бүрдүүлэх, удирдахтай холбоотой харилцааг ТХОУ-ын тухай хуулиар зохицуулах тухай 6.3 дахь хэсэг тус бүрийг нэмж тусгалаа.
- 16) ТХОУ-ын тухай хуулийг дагаж **мөрдөх журмын тухай** хуулийн төсөл болон Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай **УИХ-ын тогтоол**ын төслийг тус тус боловсруулсан.

---o0o---